



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/017/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Аудитын менежер: Б.Батмөнх	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Утас: 7036-3036 Аудитор: Утас: 7036-3047	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Б.Наранцэцэг Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-22
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-21
4. Аудитын тайлан	22-25
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
5. Аудитын илрүүлэлт	25-30
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	31-32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АҮТХ	Ажил үйлчилгээний төлбөр хураамж
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ЕРӨӨ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.ОДГАРАВ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № *СА-2025/019/НА-ТА-ТЗ*

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, 25 дугаар зүйлийн 25.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5-д заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын төсвийн орлогын төлөвлөгөөг **2,389,462.9** мянган төгрөгөөр тасалсан,
- ЗДТГ, ИТХ, Бугант тосгоны Захирагчийн алба нь батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд

гүйлгэн, **81,157.1** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаагүй,

- ЗДТГ, ИТХ, Бугант тосгоны Захирагчийн алба нь албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас нийт **5,423.0** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй,
- ЗДТГ, Бугант тосгоны Захирагчийн алба нь албан хаагчдад **913.2** мянган төгрөгийн цалин, урамшууллыг илүү тооцож, олгосон,
- Бугант тосгоны Захирагчийн алба нь баталсан бүтэц, орон тоог хэтрүүлсэн буюу орон тоонд батлагдаагүй биеийн тамирын арга зүйч ажиллуулж, цалин урамшууллын зардалд **25,247.8** мянган төгрөгийг зарцуулсан,
- Бугант тосгоны Захирагчийн алба нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан буюу **2,500.0** мянган төгрөгийн хандив төвлөрүүлж, зарцуулсан.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн “2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 142 дугаар тогтоолоор Ерөө сум нь тайлант онд 8,417,564.5 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 6,028,101.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 71.6 хувьтай буюу 28.4 хувиар тасарсан байна.

Аудитын гол асуудал

Тус сумын авлага дансны үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан боловч өнөөг хүртэл барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Үүнд:

- ОНЕО-ын дансанд 2006 онд олгосон итгэлийн зээлийн 8,180.0 мянган төгрөгийн, 2023 онд ОНХС-ийн санхүүжилтийг илүү олгосон 3,511.8 мянган төгрөгийн,
- ЗДТГ-ын авлагын дансны үлдэгдэлд ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжсэн бохирын машин нийлүүлэх тендерт шалгарсан компанид шилжүүлсэн урьдчилгаа 14,000.0 мянган төгрөгийн, 2022 онд хүүхдийн тоглоомын талбай хийлгэх ажлын урьдчилгаа 12,000.0 мянган төгрөгийн гэх мэт.

Бусад асуудлын хэсэг

Ерөө сумын Бугант тосгоны цэвэрлэх байгууламж нь цахилгааны 12,422.0 мянган төгрөгийн өр төлбөртэйн улмаас цахилгааны хязгаарлалт хийгдэж, үйл ажиллагаа зогсон, хөлдөх эрсдэл үүссэн тул Засаг даргын нөөц хөрөнгөөс уг өр төлбөрийг барагдуулж, арга хэмжээ авч ажилласан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,382,808.30	1,508,437.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,477,110.90	909,894.20
33	АВЛАГА	642,898.20	365,773.60
35	БАРАА МАТЕРИАЛ	1,262,799.20	232,769.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,178,054.20	13,985,115.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,178,054.20	13,985,115.80
39200	Биет хөрөнгө	5,931,488.90	13,125,516.40
39300	Биет бус хөрөнгө	246,565.30	859,599.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,560,862.50	15,493,553.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	262,438.50	414,558.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	262,438.50	414,558.50
41300	Өглөг	262,438.50	414,558.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,298,424.00	15,078,994.90
51	Засгийн газрын хувь оролцоо	10,298,424.00	15,078,994.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,461,774.50	1,461,774.50
51200	Хуримтлагдсан үр дүн	8,252,753.20	13,033,324.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	583,896.30	583,896.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,560,862.50	15,493,553.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,715,917.40	15,871,705.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,328,327.30	5,663,448.90
110	Орлогын албан татвар	5,988,957.80	4,596,500.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,086,338.90	4,688,926.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(97,381.00)	-92,425.90
113	Хөрөнгийн албан татвар	131,366.90	93,815.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,208,002.60	973,132.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	946,257.60	6,650,198.10
120	Нийтлэг татварын бус орлого	946,257.60	6,650,198.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,441,332.40	3,558,058.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,309,484.80	6,704,497.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,097,275.80	6,329,983.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,277,000.80	5,140,448.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,001,102.50	1,348,750.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,999.50	174,724.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,380.30	1,566,659.30
2104	Хангамж, бараа материалын зардал	120,171.90	106,822.20
2105	Нормативт зардал	546.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,681.20	81,382.80
2107	Томилолт, зочны зардал	9,053.20	15,906.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,458,331.90	121,623.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,195,734.30	1,724,579.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,820,275.00	1,189,535.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	212,209.00	374,513.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,406,432.60	9,167,208.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,347,242.00	4,368,793.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,059,190.60	4,798,415.50

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	9,081,559.00	9,938,742.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,328,327.30	5,663,448.90
110	Орлогын албан татвар	5,988,957.80	4,596,500.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,086,338.90	4,688,926.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(97,381.00)	-92,425.90
113	Хөрөнгийн албан татвар	131,366.90	93,815.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,208,002.60	973,132.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	41,203.40	45,428.00
1181	Газрын төлбөр	387,559.00	374,100.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	779,240.10	553,604.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	361,446.70	769,639.40
120	Нийтлэг татварын бус орлого	361,446.70	769,639.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,391,785.00	3,505,654.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,531,385.50	6,026,197.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,531,385.50	6,026,197.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,711,110.60	4,836,662.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,001,100.10	1,353,217.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,532.30	174,111.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,380.30	1,562,289.30
2104	Хангамж, бараа материалын зардал	119,505.90	112,407.30
2105	Нормативт зардал	546.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,681.20	79,683.80
2107	Томилолт, зочны зардал	9,053.20	15,906.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,488,071.90	123,353.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	605,239.70	1,415,693.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,820,275.00	1,189,535.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,550,173.50	3,912,545.20
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,764,987.70	5,479,761.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,764,987.70	5,479,761.90
2200	Дотоод эх үүсвэрээр	2,764,987.70	5,479,761.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,764,987.70)	-5,479,761.90
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(60,000.00)	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(60,000.00)	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(274,814.20)	-1,567,216.70
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,751,925.10	2,477,110.90
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,477,110.90	909,894.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	9,240,915.40	0.00	9,240,915.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,682.00)	0.00	(1,682.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,239,233.40	0.00	9,239,233.40
4	Тайлант үеийн үр дүн	1,059,190.60	0.00	1,059,190.60
5	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,298,424.00	0.00	10,298,424.00
6	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	10,298,424.00	0.00	10,298,424.00
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(17,844.60)	0.00	(17,844.60)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,280,579.40	0.00	10,280,579.40
9	Тайлант үеийн үр дүн	4,798,415.5	0.0	4,798,415.5
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,078,994.9	0.0	15,078,994.9

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,503,982.10	10,098,527.73	2,405,454.37	80.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,401,968.20	4,672,838.75	729,129.45	86.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,310,740.20	4,584,145.53	726,594.67	86.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,444,992.40	1,353,217.35	91,775.05	93.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,428.50	174,111.20	6,317.30	96.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,604,677.10	1,562,289.32	42,387.78	97.4
2104	Хангамж, бараа материалын зардал	120,471.50	110,003.26	10,468.24	91.3
2105	Нормативт зардал	1,000.00	0.00	1,000.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	132,244.60	115,565.92	16,678.68	87.4
2107	Томилолт, зочны зардал	15,447.40	10,146.70	5,300.70	65.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,570.00	123,353.52	37,216.48	76.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,650,908.70	1,135,458.25	515,450.45	68.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,228.00	88,693.22	2,534.78	97.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,228.00	88,693.22	2,534.78	97.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,888,313.90	5,425,688.98	1,462,624.92	78.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	213,700.00	0.00	213,700.00	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,503,982.10	10,154,431.11	2,349,550.99	81.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,215,457.90	9,766,988.98	448,468.92	95.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,288,524.20	387,442.13	1,901,082.07	16.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	455,540.72	-455,540.72	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	511,444.10	-511,444.10	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	94	94	0.0	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	0.0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	45	45	0.0	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/мянган төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	668,960.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,960.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,149.26
2104	Хангамж, бараа материалын зардал	2,404.00
2107	Томилолт, зочны зардал	5,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	375,985.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	264,811.17
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	264,811.17
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	264,811.17
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	668,960.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	668,960.43
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,300.11
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	280,474.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	306,686.07

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ерөө сумын ТТЗ нь тайлант оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэж, төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэхэд оршино”* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2024 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийсэн бөгөөд ХХС-ийн дутуу тооцоолсон алдангийн зөрчилд акт хүргүүлсэн, ОНХО, ОНХС-ын төлөвлөлтэй холбоотой албан шаардлага, зөвлөмж өгсөн бол төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу Бугант тосгоны захирагчийн албаны санхүүгийн үйл ажиллагаанд болон ЗДТГ, ИТХ, Ойн ангийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ерөө сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус сумын ТТЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,932,690.9 мянган төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,477,110.9	909,894.2	-1,567,216.7
Авлага	642,898.2	365,773.5	-277,124.7
Бараа материал	1,262,799.2	232,769.9	-1,030,029.3
Үндсэн хөрөнгө	6,178,054.2	13,985,115.8	7,807,061.6
Нийт хөрөнгө	10,560,862.5	15,493,553.4	4,932,690.9
Өр төлбөр	262,438.5	414,558.5	152,120.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,298,424.0	15,078,994.9	4,780,570.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,560,862.5	15,493,553.4	4,932,690.9

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 909,894.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,567,216.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	2,477,110.9	909,894.2	-1,567,216.7
Дүн	2,477,110.9	909,894.2	-1,567,216.7

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын 302,080.5 мянган төгрөг, ОНХС-ийн 246,958.3 мянган төгрөг, нөхөн сэргээлтийн

барьцаа хөрөнгийн 96,369.6 мянган төгрөг, ХХС-ийн 264,485.8 мянган төгрөг тус тус тайлагнагдсан байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 365,773.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 277,124.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	39,837.7	25,115.4	-14,722.3
Байгууллагаас авах авлага	203,575.6	82,750.5	-120,825.1
Хувь хүмүүсээс авах авлага	32,201.2	32,141.3	-59.9
Хувь хүмүүст олгосон зээл	367,283.7	225,766.3	-141,517.4
Дүн	642,898.2	365,773.5	-277,124.7

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд сумын ЗДТГ-ын 56,379.5 мянган төгрөгийн /зураг төсвийн ажил нь хийгдээгүй байгаагаас авлага үүссэн/, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 26,000.0 мянган төгрөгийн /бохирын машины 14.0 сая төгрөгийн урьдчилгаа буюу тендерээр нийлүүлэгдсэн машин нь шаардлага хангаагүйгээс буцааж, шүүхэд шилжүүлэн шийдвэр нь гарсан, 2022 онд тоглоомын талбай хийлгэхээр 12.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон бөгөөд ажил хийгдээгүй учир цагдаагийн байгууллагад шилжүүлсэн/, хоршоо хөгжүүлэх сангийн 271,702.2 мянган төгрөгийн, орон нутгийн ерөнхий орлогын 11,691.8 мянган төгрөгийн /ОНХС-ийн 2023 онд илүү олгосон 3,511.8 мянган төгрөгийн санхүүжилт, 2006 онд олгосон 8,180.0 мянган төгрөгийн итгэлийн зээл/ авлагууд тус тус тайлагнагдсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 232,769.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,030,029.3 мянган төгрөгөөр буюу 5.4 дахин буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	15,785.1	14,785.2	-999.9
Бичиг хэргийн материал	-	387.5	387.5
Аж ахуйн материал	58,770.5	37,694.0	-21,076.5
Сэлбэг хэрэгсэл	250.0	250.0	0.0
Түлш, шатах тослох материал	-	5,600.0	5,600.0
Барилгын засварын материал	1,022,764.3	0.0	-1,022,764.3
Бусад хангамжийн материал	91,029.3	99,853.2	8,823.9
Мал амьтад	74,200.0	74,200.0	0.0
Дүн	1,262,799.2	232,769.9	-1,030,029.3

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,030,029.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 286,897.3 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан, ИТХ шатахууны урамшуулалд 420.0 мянган төгрөгийн талон үнэ төлбөргүйгээр, сумын 100 жилийн ой тохиосонтой холбоотойгоор бий болсон 28,317.2 мянган төгрөгийн бараа материалыг бусад эх үүсвэрээс тус тус хүлээн авч, сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн 1,022,764.3 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагад хүлээлгэж өгсөн, 322,899.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 16,527,655.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2 дахин өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	7,759,235.1	15,631,310.3	7,872,075.2
Барилга, байгууламж, орон сууц	3,606,926.9	5,019,452.9	1,412,526.0
Авто-тээврийн хэрэгсэл	980,233.7	1,237,996.1	257,762.4
Машин тоног төхөөрөмж (компьютер)	478,979.3	730,127.7	251,148.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	143,386.2	208,957.3	65,571.1
Зам гүүрийн байгууламж	865,757.6	3,475,732.6	2,609,975.0
Дуусаагүй барилга	184,220.0	2,571,780.9	2,387,560.9
Бусад үндсэн хөрөнгө	1,499,731.4	2,387,262.8	887,531.4
Биет бус хөрөнгө	282,847.8	896,345.6	613,497.8
Программ хангамж	6,560.0	7,810.0	1,250.0
Бусад биет бус хөрөнгө	276,287.8	888,535.6	612,247.8
Дүн	8,042,082.9	16,527,655.9	8,485,573.0

Эх сурвалж: Ерөө сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 8,485,573.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,356,902.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, хандиваар 149,569.4 мянган төгрөгийн /Ойн ангид 133,126.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 16,443.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил/ хөрөнгө хүлээн авсан, аймгийн хөрөнгө оруулалт болон сумын ОНХО, ОНХС, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 4,836,628.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан, ЗДТГ нь 612,247.8 мянган төгрөгийн өртөг бүхий газрыг үнэлж, биет бус хөрөнгөд бүртгэсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 414,558.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 152,120.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	4,467.2	638.0	-3,829.2
Байгууллагад төлөх өглөг	257,971.3	413,920.5	155,949.2
Дүн	262,438.5	414,558.5	152,120.0

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд ОНХС-ийн 3,645.1 мянган төгрөгийн, барьцаа хөрөнгийн дансны 96,369.5 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн 2,767.3 мянган төгрөгийн /2010-2012 онд олгосон "Итгэлийн зээл", нэр данс зөрүү орлого/, Ерөө соёлын төвийн 2024 оны халаалтын зардлын 4,370.0 мянган төгрөгийн, ЗДТГ-ын 306,768.5 мянган төгрөгийн /барьцаа хөрөнгийн 5 хувь, олгоогүй байгаа санхүүжилтийн үлдэгдэл/, ИТХ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн 638.1 мянган төгрөгийн өр төлбөр тус тус тайлагнагдсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 15,079,726.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,781,302.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,461,774.5	1,461,774.5	0.0
Хуримтлагдсан үр дүн	8,252,753.2	13,033,324.2	4,780,571.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	583,896.3	583,896.3	0.0
Дүн	10,298,424.0	15,078,995.0	4,780,571.0

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн 4,780,571.0 мянган төгрөгөөр өссөн нь 612,247.8 мянган төгрөгийн өртөг бүхий газрыг үнэлж, биет бус хөрөнгөд бүртгэсэн болон 2,609,975.0 мянган төгрөгийн өртөг бүхий замыг хөрөнгөд бүртгэж авсан зэргээс тус тус голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "2024 оны тодотгосон төсөв батлах тухай" 142 дугаар тогтоолоор Ерөө сум нь тайлант онд 8,417,564.5 мянган төгрөгийн татварын болон татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 6,028,101.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 71.6 хувьтай буюу 28.4 хувиар тасарсан байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар	6,750,511.1	4,184,184.6	-2,566,326.5	62.0
Үйл ажиллагааны орлого	242,200.0	426,774.0	184,574.0	176.2
Хөрөнгө борлуулсны орлого	13,000.0	14,776.2	1,776.2	113.7
Хадгаламжийн хүүгийн орлого	61,462.2	63,191.9	1,729.7	102.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-92,425.9	-92,425.9	0.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	20,000.0	19,260.2	-739.8	96.3
Бууны албан татвар	4,500.0	4,860.0	360.0	108.0
Малын тоо толгойн албан татвар	120,000.0	69,695.4	-50,304.6	58.1
Улсын тэмдэгтийн хураамж	10,000.0	10,467.1	467.1	104.7
Хог хаягдлын хураамжийн орлого	18,000.0	18,315.8	315.8	101.8
Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр	12,000.0	16,645.0	4,645.0	138.7
Газрын төлбөр	320,000.0	350,864.1	30,864.1	109.6
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	10,000.0	23,236.4	13,236.4	232.4
Ойн нөөц ашигласны төлбөр	667,735.0	536,817.6	-130,917.4	80.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	7,486.5	5,306.9	-2,179.6	70.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	11,462.3	11,479.6	17.3	100.2
Нэр заагдаагүй бусад орлого	91,633.3	98,152.4	6,519.1	107.1
Хүү, торгуулийн орлого	150,000.0	266,500.3	116,500.3	177.7
НИЙТ ДҮН	8,417,564.5	6,028,101.6	-2,389,462.9	71.6

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлогын төлөвлөгөө 2,389,462.9 мянган төгрөгөөр тасарсан нь цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 2,566,326.5 мянган төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 50,304.6 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 130,917.4 мянган төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Үйл ажиллагааны орлого: “Эрдэнэс Тавантолгой” ХК иргэдэд хувьцааны ногдол ашиг хуваарилсантай холбоотой,
- Газрын төлбөр, дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлого: тайлант онд дуудлага худалдаагаар иргэн, аж ахуйн нэгжид газар олголт нэмэгдсэнтэй холбоотой,

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр: Сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн асфальт бетон, хайрган замын ажлуудад ашиглагдсан элс, хайрганы төлбөрийн орлого нэмэгдсэнтэй холбоотой,
- Хүү, торгуулийн орлого: Байгаль орчны торгууль, торгох ялын төлбөр орсноос давж төлөвлөгөө биелсэн байна.

Тасарсан орлогууд:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар: “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн ХХОАТ 10 дугаар сараас эхлэн тасарсантай холбоотой,
- Малын тоо толгойн албан татвар: татварын байцаагчийн орлогын төвлөрүүлэлт хангалтгүйгээс,
- Ойн нөөц ашигласны төлбөр: аймгийн ИТХ-аар модны хуваарийг багаар баталсантай холбоотой.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр: аймгийн ИТХ-аар ангийн хуваарийг багаар баталсантай холбоотой.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд татварын болон татварын бус орлогыг 4,452,589.5 мянган төгрөгөөр, зарлагыг 3,932,286.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 116 дугаар “сумын 2024 оны төсөв батлах тухай” тогтоолоор санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- Татварын болон татварын бус орлогыг 9,076,096.3 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогыг 123,558.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс 1,703,707.9 мянган төгрөг,
- ОНХС-ийн эхний үлдэгдлээс 264,258.3 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,073,532.5 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 100,000.0 мянган төгрөг,
- ХХС-ийн эхний үлдэгдлээс 117,000.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **14,458,153.0** мянган төгрөг, зарлагыг **12,256,469.0** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт **2,201,684.0** мянган төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор:

- Татварын болон татварын бус орлогыг 658,531.8 мянган төгрөгөөр бууруулж 8,417,564.5 мянган төгрөг,

- Төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогыг 123,558.0 мянган төгрөг,
- Урьд оны дансны үлдэгдлээс 1,703,707.9 мянган төгрөг,
- ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих 244,258.3 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,211,807.4 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 100,000.0 мянган төгрөг,
- ХХС-ийн урд оны үлдэгдлээс 117,000.0 мянган төгрөг зэрэг сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **13,917,896.1** мянган төгрөг, зарлагыг **12,503,982.1** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг **1,413,914.0** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр **12,503,982.1** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,401,968.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 6,888,313.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 213,700.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогыг 6,028,101.6 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 243,417.8 мянган төгрөгөөр, ХХС-ийн эргэн төлөлтийн 144,024.3 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох шилжүүлгийг 3,099,394.2 мянган төгрөгөөр зэрэг нийт **9,514,937.9** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн, **1,100,842.2** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **10,098,527.7** мянган төгрөг буюу 80.8 хувьтай тайлагнагдсан нь ХХС-ийн зээл олгоогүй болон ТШЗ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна. Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 91,775.0 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 6,317.3 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 42,387.7 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардал 10,468.2 мянган төгрөгөөр,
- Нормативт зардал 1,000.0 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 16,678.7 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардал 5,300.7 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 37,216.5 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 515,450.4 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 2,534.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 19 төсөл, арга хэмжээнд 3,338,588.2 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр

2,102,829.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 1,189,419.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 4 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 1 төсөл арга хэмжээ он дамжсан, 2 төсөл, арга хэмжээ бүрэн дууссан боловч санхүүжилт бүрэн олгогдоогүй зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 26 төсөл, арга хэмжээнд 3,596,065.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 3,322,868.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 273,196.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 2 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн, 4 төсөл арга хэмжээ он дамжсан зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 280,474.3 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 79,300.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 306,686.1 мянган төгрөг, хандивын орлого 2,500.0 мянган төгрөг зэрэг нийт **668,960.5** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнээс:

- Бичиг хэргийн зардалд 644.0 мянган төгрөг,
- тээвэр, шатахууны зардалд 1,760.0 мянган төгрөг,
- Албан томилолтын зардалд 5,760.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардалд 375,985.3 мянган төгрөг,
- Хөрөнгийн зардалд 20,000.0 мянган төгрөг /Угтах самбарын гадна талбайн тохижилтын зураг төсвийн үнэ/ зэрэг нийт **404,149.3** мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл **264,811.2** мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд сумын ОНХО, ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн харьцуулалт болон нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 26 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 9. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эх үүсвэр	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ		Үүнээс:					
			Гэрээ шууд байгуулах		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	19	3,338,588.2	11	323,380.0	3	182,042.0	5	2,833,166.2
Сумын ОНХС	26	3,596,065.7	9	357,450.0	6	488,546.7	11	2,755,869.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Ерөө сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт болон бараа материалын данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын ТТЗ нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 106 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 7,309,484.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 73,094.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 42,387.8 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 10,468.2 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 5,300.7 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 16,678.7 мянган төгрөгөөр,
- Тус сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагддаг 10 автомашинд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 49 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад хууль тогтоомжийг зөрчсөн нийт **4,879.6** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас аймгийн Засаг даргын захирамжаар видео контент хийлгэхээр “Монголын баялаг өв соёл ХХК”-тай гэрээ байгуулан **4,879.6** мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн боловч гэрээт ажлыг хүлээн аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниуулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 10. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Огт мэдээлээгүй
1	ТТЗ	157	147	10	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	168	3	-
3	Засаг даргын Тамгын газар	171	168	3	-
4	Бугант тосгоны Захирагчийн алба	171	162	9	-
5	Ерөө бүсийн Ойн анги	171	171	-	-
	Нийт дүн	841	817	24	-

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 172 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 дугаар улирлын санхүүгийн тайланд шинжилгээ хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,122.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 59,191.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 84.6 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,122.9	3	1,122.9	100.0
Албан шаардлага	8	59,191.4	6	43,821.4	75.0
Зөвлөмж	2		2		100.0
Нийт дүн	13	60,314.3	11	44,944.3	84.6

Эх сурвалж: Ерөө сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бугант тосгоны Захирагчийн алба нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан буюу батлагдсан төсвийг

зориулалт бусаар зарцуулсан, хандив авсан зэрэг зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу Бугант тосгоны Захирагч Д.Эрдэнэбулган, нягтлан бодогч Б.Жавхланзаяа нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн 2024 оны зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт **22,636.9** мянган төгрөгийн залруулаагүй алдаанд¹ зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулаагүй алдаа:

- ИТХ нь 11,800.0 мянган төгрөгийн авто машины урсгал засварыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн,
- ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн данснаас 4,850.0 мянган төгрөгийн өвс, тэжээл худалдан авсан боловч бараа материалын дансанд орлогод аваагүй,
- Ойн анги нь 2022 онд орлогод авсан 5 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоогоогүйгээс нийт 5,986.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулаагүй,

Шийдвэрлэлт: 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **2,521,376.1** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **6,336.2** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **2,498,367.8** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **16,672.1** мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу орон нутагт

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас нийт **5,423.0** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ИТХ нь 1 албан хаагчид олгосон 8,754.9 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас **875.5** мянган төгрөгийг,
- ЗДТГ нь 5 албан хаагчид олгосон 37,555.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас **3,755.5** мянган төгрөгийг,
- Бугант тосгоны Захирагчийн алба нь 1 албан хаагчид олгосон 7,920.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас **792.0** мянган төгрөгийг гэх мэт.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1: "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 22 дугаар зүйлийн 22.1 дэх "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө" 22.1.1: "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Албан хаагчдад **913.2** мянган төгрөгийн цалин, урамшууллыг илүү тооцож, олгосон дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Бугант тосгоны Захирагчийн албаны нягтлан бодогч Б.Жавхланзаяад **458.7** мянган төгрөгийн цалин,
- ЗДТГ-ын мал зүйч Э.Нандинцэцэгт **127.5** мянган төгрөгийн цалин,
- ЗДТГ-ын дарга С.Цэвэлмаад орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчид олгох **327.0** мянган төгрөгийн урамшуулал гэх мэт

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:" 20.2.5 дахь " ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин, урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант оны 10 дугаар сараас эхлэн "Болдтөмөр Ерөө гол" ХХК нь ХХОАТ-ын төлөлт хийгээгүйгээс цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын төлөвлөгөө 2,566,326.5 мянган төгрөгөөр тасарсантай холбоотой сумын төсвийн орлогын төлөвлөгөөг **2,389,462.9** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлэх үр нөлөө бүхий арга хэмжээ авсны үндсэн дээр төлөвлөсөн орлогын төлөвлөгөөг биелүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Бугант тосгоны Захирагчийн алба нь сумын ЗДТГ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоог хэтрүүлсэн буюу орон тоонд батлагдаагүй биеийн тамирын арга зүйчээр Ж.Төгсбаярыг томилон ажиллуулж, цалин урамшууллын зардалд **25,247.8** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан орон тооны хязгаарыг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан буюу Бугант тосгоны Захирагчийн алба нь нэмэлт санхүүжилтийн дансаар аж ахуйн нэгж, байгууллагаас **2,500.0** мянган төгрөгийн хандивын орлого төвлөрүүлж, ахмадын баярын зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.”, 25.2.1 дэх “эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2 дахь “бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3 дахь “соёлын үйлчилгээ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.4. Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй дараах **81,157.1** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөөс ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан ЗДТГ-ын байрны ариун цэврийн байгууламжийн засварын зардлын **16,000.0** мянган төгрөг, сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээний **11,200.0** мянган төгрөг,

2. ЗДТГ нь нийт **11,978.5** мянган төгрөг:

2. ЗДТГ нь нийт 11,978.5 мянган төгрөг:

- Байгууллагын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын батлагдсан төсвөөс албан хаагчдад олгох дэвтэр, балын үнэд 870.0 мянган төгрөг /29 ширхгийг 30.0 мянган төгрөгөөр/,
- Бусад нийтлэг АҮТХураамжаас шатахууны зардалд 1,584.3 мянган төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн арга хэмжээний зардалд 2,478.5 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас сургалтын зардалд 1,500.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 450.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 900.0 мянган төгрөг,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас зочин төлөөлөгч хүлээн авахад 4,195.7 мянган төгрөг,

3. ИТХ нь цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1,918.7 мянган төгрөг,

4. Бугант тосгоны Захирагчийн алба нь нийт 31,419.9 мянган төгрөг:

- Орон нутгийн чанартай авто замын засвар үйлчилгээний арга хэмжээний зардлаас наадмын талбайн дээврийн засвар болон гэрэлт цогцолборын тохижилтын зардалд 25,162.9 мянган төгрөг,
- Хур хог хаягдал, орчны бохирдлын зардлаас гудамжны гэрэлтүүлгийн засварын зардалд 1,480.0 мянган төгрөг,
- Бусад нийтлэг АҮТХураамжаас мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 900.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас урсгал засварын зардалд 727.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 293.0 мянган төгрөг, бусад нийтлэг АҮТХураамжид 201.9 мянган төгрөг,
- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалингийн зардалд 2,654.2 мянган төгрөг,

5. Сумын засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг иргэдэд хүргэх зорилгоор сэтгүүлийн хэвлэлийн төлбөрт 8,640.0 мянган төгрөг /1800 ширхэг 4800 төгрөгөөр/ гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх "Нөөц хөрөнгийг зарцуулах тухай Засаг даргын шийдвэрийн төсөл нь дор дурдсан шаардлагыг хангасан байна: 3.1.2: урьдчилан төлөвлөх боломжтой... зардал ...", 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.5. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буюу бусдаас хандив, тусламж авч зарцуулсан, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан сумын Бугант тосгоны Захирагч Д.Эрдэнэбулган, нягтлан бодогч Б.Жавхланзаяа нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Бараа материалын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бугант тосгоны Захирагчийн алба нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг тоо ширхэг, нэр төрөл бүрээр бус бөөн дүнгээр орлогод авч, зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын орлого, зарлагыг тухай бүр, нэр төрөл, тоо ширхгээр санхүүгийн программд бичилт хийж байх.

5.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт **16,672.1** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.4 дэх "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл бүрээр бичнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ИТХ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас хэсгийн төлөөлөгчийн эргүүлийн шатахууны зардалд шатахууны

зарцуулалтын болон гүйцэтгэсэн ажлын тайлангүйгээр /үр дүн тодорхой бус байхад сар бүр тогтмол олгосон/ нийт **7,137.8** мянган төгрөгийг,

- ИТХ нь “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар гүйцэтгэсэн ажлыг тодорхой тусгалгүйгээр илүү цагийн хөлсөнд /6,7 дугаар сард/ **1,576.3** мянган төгрөгийг,
- ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгөөс шүлхий, мялзангийн вакцины мал баригчийн ажлын тайлан, гүйцэтгэлийн баримтгүйгээр ажлын хөлс **7,958.0** мянган төгрөгийг олгосон гэх мэт

Өгсөн зөвлөмж: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

5.3.3 Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрч буй өвс, тэжээлийн тооцоог данс бүртгэлээр дамжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “... удирдлага, нягтлан бодогч нь ... үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалын орлого, зарлагыг тухай бүр санхүүгийн программд бичилт хийж байх.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн		
							Тоо	Дүн	Тоо	Дүн				
ИТХ	1	11,800.0			1	11,800.0			1	11,800.0	1	11,800.0		
ЗДТГ	1	4,850.0	1	4,850.0					1	4,850.0	1	4,850.0		
Ойн анги	1	5,986.9	1	5,986.9					1	5,986.9	1	5,986.9		
Нийт дүн	3	22,636.9	2	10,836.9	1	11,800.0			3	22,636.9	3	22,636.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	4	2,433,260.9			3	2,425,302.9	1	7,958.0				
ИТХ	3	11,508.3	1	875.5	1	1,918.7	1	8,714.1				
ЗДТГ	4	16,188.5	2	4,210.0	1	11,978.5	1	0.00				
Бугант тосгоны Захирагчийн алба	7	60,418.4	2	1,250.7	3	59,167.7	1	0.00			1	2
Дүн	17	2,521,376.1	5	6,336.2	8	2,498,367.8	4	16,672.1	1	2	1	2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
			Төлбөрийн акт		Албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Дүн							
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт							
Сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн	1	4,879.6			1	4,879.6	
Дүн	1	4,879.6			1	4,879.6	
Нийт дүн	1	4,879.6			1	4,879.6	